



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга шалгаруулах хонхтой бөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Хонхтой бөмбөг”-ийн тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.710.000 /нэг сая долоон арван мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг /-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ж.ГАНБОЛД



1150500052


Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны...03 дугаар... сарын 09-ны өдрийн
А/Б дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
“Хонхтой бөмбөг”-ийн
тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 10 x 25.000 төг = 250.000 төг 10 x 20.000 төг = 200.000 төг 10 x 15.000 төг = 150.000 төг	600.000
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /10 хүн x 2 өдөр x 20.000 төг/	400.000
3.	Заал талбайн зардал	250.000
4.	Өргөмжлөл	60.000
5.	Медаль:	300.000
6.	Анонс, цом	50.000
7.	Тээврийн хөлс	50.000
Нийт дүн		1.710.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны... дугаар... сарын 09-ны өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
“Хонхтой бөмбөг”-ийн тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | В.Дуламсүрэн |
| 2. Шүүгч | Ө.Баасанжарал |
| 3. Шүүгч | Ц.Мөнхдэлгэр |
| 4. Шүүгч | П.Туул |
| 5. Шүүгч | С.Сүх-Очир |
| 6. Шүүгч | Б.Анхбаяр |
| 7. Шүүгч | Б.Наранцэцэг |
| 8. Шүүгч | Ж.Лхагважав |
| 9. Шүүгч | Д.Хишгээ |
| 10. Шүүч | Ж.Ариунаа |